



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/371

Ховд

Дэд хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/131 дүгээр тушаал, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөл сонгон шалгаруулах дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Дэд хорооны дарга: Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Гишүүд: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Т.Сайнбаяр - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын орлогч дарга
- Д.Дариймаа - Хүнсчдийн холбооны тэргүүлэгч
- Э.Энхсайхан - Баялаг бүтээгчдийн холбооны дарга
- Б.Батсүх - Хөдөө аж ахуйн хоршоологч холбооны тэргүүн
- Т.Эрдэнэцэцэг - Ховд Бат Итгэл ТББ-ын гүйцэтгэх захирал
- Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэдорж - Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн

2.Төсөл сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу шударга нээлттэй ил тод шуурхай зохион байгуулж тайлагнахыг дэд хорооны дарга /Б.Бямбажав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ